



Японы Олон Улсын Хамтын Ажиллагааны Байгууллага (ЖАЙКА)
Монгол дахь Төлөөлөгчийн газар

ТАНИЛЦУУЛГА



JICA at a Glance

ИЕНИЙ ХӨНГӨЛӨЛТТЭЙ ЗЭЭЛ

1,829
ТЭРБУМ ИЕН

(2023 оны байдлаар)



БУЦАЛТГҮЙ ТУСЛАМЖ

873
ТЭРБУМ ИЕН

(2023 оны байдлаар)



ТЕХНИКИЙН ХАМТЫН АЖИЛЛАГАА

603
ТЭРБУМ ИЕН

(2023 оны байдлаар)



МОНГОЛ УЛСАД ТОМИЛОГДОН АЖИЛЛАСАН САЙН ДУРЫН ГИШҮҮДИЙН ТОО

1992 оноос хойш нийт

772 хүн



Одоогийн байдлаар нийт

41 хүн

(2025.5 сарын байдлаар)

ЯПОН БОЛОН ГУРАВДАГЧ ОРОН ДАХ СУРГАЛТАД ОРОЛЦОГЧДЫН НИЙТ ТОО




7,038
хүн

(1977-2024.3 сар)

ТӨСВИЙН ОРЛОГЫН БААЗ СУУРИЙГ БЭХЖҮҮЛЭХЭД ОРУУЛСАН ХУВЬ НЭМЭР

ТАТВАРЫН ОРЛОГЫН ДҮНГИЙН ӨӨРЧЛӨЛТ

(1 тэрбум төгрөг)



Эх сурвалж: Татварын Ерөнхий Газар

ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ӨСӨЛТӨД ОРУУЛСАН ХУВЬ НЭМЭР


ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН
ҮНЭЛГЭЭНИЙ ДНБ-Д ЭЗЛЭХ ХУВЬ



Эх сурвалж: ЦЗХ

БИРЖИЙН БУС ЗАХ ЗЭЭЛИЙГ ХӨГЖҮҮЛЭХЭД ОРУУЛСАН ХУВЬ НЭМЭР

БИРЖИЙН БУС ЗАХ ЗЭЭЛЭЭР
ТАТАН ТӨВЛӨРҮҮЛСЭН ДҮНГИЙН
ДНБ-Д ЭЗЛЭХ ХУВЬ



Эх сурвалж: МҮЦАЭХ

ОРОН НУТГИЙН ХАМТЫН АЖИЛЛАГАА

"ӨВСНИЙ ҮНДЭС"
ТЕХНИКИЙН ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ
ХҮРЭЭНД ХАМТРАН АЖИЛЛАСАН
ОРОН НУТГИЙН ЗАСАГ ЗАХИРГААНЫ
БАЙГУУЛЛАГЫН ТОО:

19
байгууллага

(2003-2024 он)



ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ЗОРИЛТЫН БИЗНЕСИЙГ ДЭМЖИХ СУДАЛГАА (JICA BIZ) -НЫ ХҮРЭЭНД ХЭРЭГЖҮҮЛСЭН ХУВИЙН ХЭВШЛИЙН ХАМТЫН АЖИЛЛАГАА

35

(2015-2024 он)





УЛААНБААТАР
ХОТЫН
УНДНЫ УСНЫ
ХЭРЭГЛЭЭНИЙ

70

ОРЧИМ
ХУВИЙГ ХАНГАДАГ

(2025 он)



ЭРЧИМ ХҮЧ; СЭРГЭЭГДЭХ
ЭРЧИМ ХҮЧНИЙ
СУУРИЛАГДСАН ХҮЧИН
ЧАДЛЫН

17

ОРЧИМ ХУВИЙН
ЦАХИЛГААН ЭРЧИМ ХҮЧ

(2023 он)



ЧИНГИС ХААН ОЛОН
УЛСЫН НИСЭХ БУУДЛЫН
ЗОРЧИГЧДЫН ТОО

2,180,000
хүн

(ОЛОН УЛС +
ДОТООДЫН НИСЛЭГ)

(2024 он)



ИНЖЕНЕР ТЕХНОЛОГИЙН ДЭЭД БОЛОВСРОЛЫГ ДЭМЖИХ ТӨСӨЛ (MJEED/1000
ИНЖЕНЕР ТӨСӨЛ) ИЕНИЙ ХӨНГӨЛӨЛТТЭЙ ЗЭЭЛ

Япон Улсад суралцсан оюутны тоо



Коосэн

177 оюутан



Бакалавр

292 оюутан



Магистр

37 оюутан



Доктор

104 оюутан

Япон Улсад
богино
хугацаагаар
илгээсэн
багш
оюутны тоо

535
хүн

Япон Улсын
их, дээд
сургуультай
хамтран
хэрэгжүүлж
буй судалгааны
тоо

26
судалгаа

Япон Улсын хамтран ажилладаг
боловсролын байгууллагын тоо

КООСЭН
СУРГУУЛЬ

51
сургууль

ХАМТАРСАН
СУДАЛГАА
ХЭРЭГЖҮҮЛЖ
БУЙ ИХ
СУРГУУЛЬ

60
их
сургууль

ХОСОЛСОН
ХӨТӨЛБӨРИЙГ
ХАМТРАН
ХЭРЭГЖҮҮЛЖ
БУЙ ИХ СУРГУУЛЬ

10
их
сургууль

(2014-2025)



ТӨВЛӨРСӨН
ХОГИЙН ЦЭГ:
УЛААНБААТАР
ХОТООС ГАРАХ
НИЙТ ХОГ ХАЯГДЛЫН

45

ХУВИЙГ
БОЛОВСРУУЛДАГ

(2025 он)



ЖИЖИГ ДҮНД ҮЙЛДВЭРИЙГ ХӨГЖҮҮЛЭХ, БАЙГАЛЬ
ОРЧНЫГ ХАМГААЛАХ ХОЁР-ҮЕ ШАТТАЙ ЗЭЭЛИЙН ТӨСӨЛ

ШИНЭ АЖЛЫН
БАЙРНЫ ТОО:

27,466
хүн

САНХҮҮЖҮҮЛСЭН ТӨСЛИЙН ТОО:

1,026 төсөл

Улаанбаатар хотод

594
төсөл

Орон нутагт

432
төсөл

САНХҮҮЖИЛТИЙН НИЙТ ДҮН: **15,367.0** сая иен

(2006-2025 он)



"МОНГОЛ-ЯПОНЫ
БИЗНЕС ФОРУМ"-Д
ОРОЛЦОГЧДЫН ТОО

Япон Улс

350
хүн

Монгол Улс

1,100
хүн

(2022-2024 он, 3 удаагийн
форумын дундаж)



"МОНГОЛ-ЯПОНЫ
ХҮНИЙ НӨӨЦИЙН
ХӨГЖЛИЙН ТӨВ"-ИЙН
БИЗНЕСИЙН СУРГАЛТЫГ
ТӨГСӨГЧДИЙН ТОО

39,840
хүн

(2002-2025.5 сарын
байдлаар)



СУРГАЛТАНД
ХАМРАГДСАН МАЛЫН
ЭМЧ НАРЫН ТОО

2,248хүн

НИЙТ МАЛЫН ЭМЧ
НАРЫН

70%

(2014-2025 он)



БЭЛТГЭЖ СУРГАСАН
АЖЛЫН БАЙРНЫ
ДАДЛАГАЖУУЛАГЧИЙН
ТОО (ХӨГЖЛИЙН
БЭРХШЭЭЛТЭЙ ИРГЭДИЙН
ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТЭД
ДЭМЖЛЭГ ҮЗҮҮЛЭХ
АЖИЛТАН)

241
хүн

(2021-2025 он)



МОНГОЛ-ЯПОНЫ ЭМНЭЛЭГИЙН ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭ, СУРГАЛТ,
СУДАЛГААНЫ ОЛОЛТУУД

Амбулаториор үйлчлүүлсэн
хүний тоо

634,256 хүн

хэвтэн эмчлүүлэгч

15,672 хүн

Клиник сургалт

59 УДААГИЙН
СУРГАЛТАД НИЙТ
1,129 хүн
(давтагдсан тоогоор)
хамрагдсан

Клиник судалгаа

123

(2019-2025 он)

ЯПОНЫ ОЛОН УЛСЫН ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ БАЙГУУЛЛАГА (ЖАЙКА)

ЖАЙКА нь Япон Улсын Засгийн газрын Хөгжлийн Албан Ёсны Тусламж (ХАЁТ)-ийн хоёр талт хамтын ажиллагааг голлон хэрэгжүүлдэг хөгжлийн тусамжийн байгууллага бөгөөд Техникийн хамтын ажиллагаа, Иений хөнгөлөлттэй зээл, Буцалтгүй тусламж зэрэг өргөн хүрээтэй хамтын ажиллагааг дэлхийн 150 гаруй улс орон, бүс нутагт хэрэгжүүлж байна.



МОНГОЛ УЛС ДАХЬ ХАМТЫН АЖИЛЛАГАА

Монгол Улс дахь Япон Улсын эдийн засгийн хамтын ажиллагаа нь 1977 онд буцалтгүй тусламжаар "Говь" ноолуурын үйлдвэрийг барьж байгуулснаар эхэлсэн. 1990 онд Монгол Улс ардчилал, зах зээлийн эдийн засагт шилжсэний дараа хамтын ажиллагаа бүрэн утгаараа хэрэгжиж эхэлсэн бөгөөд өнөөг хүртэл хэрэгжүүлсэн техникийн хамтын ажиллагаа, иений хөнгөлөлттэй зээл, буцалтгүй тусламжийн нийт дүн 330 тэрбум иенд (※1) хүрсэн байна. Мөн 1992 оноос хойш 770 гаруй сайн дурын гишүүн Монгол Улсад томилогдон ажиллаж, Монгол Улсаас 7.038 (※2) гаруй төрийн албан хаагчийг Япон Улсад зохион байгуулагдсан сургалтанд хамруулах зэргээр Монгол Улсын эдийн засаг, нийгмийн дэд бүтцийг бэхжүүлэх, хүний нөөцийг хөгжүүлэх үйл ажиллагаагаар дамжуулан хамтын ажиллагаагаа өргөжүүлж ирсэн. Япон Улс нь өнөөг хүртэл Монгол Улсын тэргүүлэх хандивлагч орон байсаар ирсэн бөгөөд энэхүү хамтын ажиллагаанд ЖАЙКА гол үүрэг гүйцэтгэж байна.

※1: 2023 оны эцсийн байдлаар. ТХА-ны тухайд ЖАЙКА-ийн төсвийн зарцуулалтын дүнгээр хөнгөлөлттэй зээл болон буцалтгүй тусламжийн дүн Засгийн газар хооронд солилцсон ноот бичгийн дүнгээр нэгтгэсэн болно.

※2: 2025.5 сарын байдлаар

ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ҮНДСЭН ХЭЛБЭРҮҮД



Техникийн хамтын ажиллагаа (ТХА)

Техникийн хамтын ажиллагааны хүрээнд Япон Улсын технологи, мэдлэг, туршлагад тулгуурлан хөгжлийн гол түлхүүр болсон хүний нөөцийг хөгжүүлэх, тогтолцоог бүрдүүлэхэд дэмжлэг үзүүлдэг бөгөөд Япон Улсаас мэргэжилтэн илгээх, Япон Улсад сургалтанд хамруулах, Техникийн хамтын ажиллагааны төсөл болон Тогтвортой хөгжилд чиглэсэн шинжлэх ухаан, технологийн хамтарсан судалгаа (SATREPS) хэрэгжүүлэх зэрэг хамтын ажиллагааны хэлбэрүүд багтдаг.

Жишээ төслүүд: Монгол Улсын сургуулийн хоол үйлдвэрлэл үйлчилгээг дэмжих төсөл



Иений хөнгөлөлттэй зээл

Иений хөнгөлөлттэй зээлийн хамтын ажиллагааны хүрээнд уян хатан нөхцлөөр санхүүжилт олгох замаар дэд бүтцийн бүтээн байгуулалт зэрэгт дэмжлэг үзүүлдэг. Мөн Хилийн чанад дахь хөрөнгө оруулалт, санхүүжилтийн хэлбэр нь хувийн хэвшилд санхүүгийн дэмжлэг үзүүлдэг хамтын ажиллагаа юм.

Жишээ төслүүд: "Улаанбаатар хотын Олон улсын нисэх онгоцны шинэ буудал барих төсөл", "Улаанбаатар хотын Дулааны 4-р Цахилгаан станцын үр ашгийг дээшлүүлэх төсөл", "Инженер, технологийн дээд боловсрол төсөл", "Төсөв, нийгэм болон эдийн засгийн шинэчлэлийн хөгжлийн бодлогын зээлийн санхүүжилтийн төсөл 2" гэх мэт.



Буцалтгүй тусламж

Эргэн төлөх нөхцөлгүйгээр санхүүжилт олгох замаар сургууль, эмнэлэг зэрэг нийгэм, эдийн засгийг хөгжүүлэхэд шаардлагатай барилга байгууламжийг барих, тоног төхөөрөмж нийлүүлэх зэргээр дэмжлэг үзүүлдэг.

Жишээ төслүүд: Бага, дунд сургуулийн барилга барих төсөл, "Япон-Монголын Сургалтын эмнэлэг барьж байгуулах төсөл", "Хүний нөөцийг хөгжүүлэх тэтгэлэгт хөтөлбөр" гэх мэт.



Иргэдийн оролцоотой хамтын ажиллагаа

ЖАЙКА нь хөгжиж буй орнуудыг Япон Улстай холбох гүүр болж, Япон Улсын иргэдийн олон улсын хамтын ажиллагааны үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж, хамтран ажилладаг. Энэхүү хамтын ажиллагааг "Иргэдийн оролцоотой хамтын ажиллагаа" гэж нэрлэдэг бөгөөд энэ хүрээнд Сайн дурын гишүүн илгээх болон "Өвсний үндэс" Техникийн хамтын ажиллагааны төсөл зэрэг олон төрлийн хамтын ажиллагааг хэрэгжүүлж байна.

Жишээ: "Монгол Улсад бие даан амьдрах төвийн чадавхыг хөгжүүлэх төсөл", "Монгол Улс-Нийгата хотын хооронд Монголын аж үйлдвэрлэлийн цахим шилжилтийн хүний нөөцийг хөгжүүлэх платформ байгуулах төсөл" зэрэг төслийг хэрэгжүүлж, боловсрол, эрүүл мэнд, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийг дэмжих, аж үйлдвэрийн салбарын боловсон хүчнийг бэлтгэх чиглэлээр ЖАЙКА-ийн сайн дурын гишүүдийг илгээж байна.



Хувийн хэвшлийн түншлэл

Жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчид гадаад зах зээлд бизнесээ өргөжүүлэхэд нь дэмжлэг үзүүлэх төсөл болон Хамтын ажиллагааны бэлтгэл судалгаа (Төр, хувийн хэвшлийн түншлэлийн дэд бүтцийн төсөл) зэргээр дамжуулан Японы ЖДҮ эрхлэгчдийн шилдэг технологи, мэдлэг, туршлагыг ашиглан хөгжиж буй орнуудын тулгамдсан асуудлыг шийдвэрлэхэд хувь нэмэр оруулдаг.

Жишээ:

- Монгол Улсад эм, эмнэлгийн хэрэгслийг дроноор тээвэрлэх сүлжээг нэвтрүүлэх бизнес хөгжүүлэлтийг баталгаажуулах судалгаа
- Сонгины шинэ сорт гарган брэнджүүлэх, сонгино тариалалтын нэмүү өртөгийн сүлжээг хөгжүүлэх төсөл

ЖАЙКА-ИЙН ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ СТРАТЕГИ

ЖАЙКА нь дараахь 3 тэргүүлэх салбар болон 6 хөгжлийн асуудлыг шийдвэрлэх арга хэмжээг хамтын ажиллагааныхаа стратеги болгон үйл ажиллагаагаа хэрэгжүүлж байна.



МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН ЭРҮҮЛ ҮЙЛ АЖИЛЛАГАА БА ЗАСАГЛАЛЫГ БЭХЖҮҮЛЭХ

1

Макро эдийн засгийг тогтворжуулж, эдийн засгийн тогтвортой өсөлтийг хангахын тулд, төрийн санхүүгийн удирдлагын чадавхыг сайжруулахын зэрэгцээ төрийн байгууллагуудын шинэ сэргэлтийг дэмжих зорилгоор засаглалын чадавхыг бэхжүүлж байна.

ХҮРЭЭЛЭН БҮЙ ОРЧИНТОЙ ЗОХИЦСОН ЭДИЙН ЗАСГИЙН ТЭНЦВЭРТЭЙ ӨСӨЛТ

2

Улаанбаатар хотын хэт төвлөрлийг сааруулж, уул уурхайгаас хараат эдийн засгийн бүтцээс ангижрахын тулд, Хүрээлэн буй орчин болон гамшгийн эрсдэлийг анхаарсан хотын дэд бүтцийг бий болгох, Аж үйлдвэрийг төрөлжүүлэх замаар бүс нутгийн хөгжлийг дэмжих чиглэлээр аж үйлдвэрийг хөгжүүлнэ.

ХЭНИЙГ Ч ОРХИГДУУЛАХГҮЙ ХҮРТЭЭМЖТЭЙ НИЙГМИЙГ ЦОГЦЛООХ

3

ЖАЙКА нь орлогын түвшин болон бүс нутгийн ялгаанаас үүдэлтэй тэгш бүс байдал (боловсрол, эрүүл мэнд, нийгмийн халамж г.м) -ыг бүүрүүлэхын тулд "Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах", "Нийгмийн суурь үйлчилгээг бэхжүүлэх"-д дэмжлэг үзүүлж, ялангуяа нийгэмд орхигдсон хүмүүст илүү үр дүн, илүү үр ашигтай нийгмийн үйлчилгээг үзүүлэхийг зорьж байна.

1 МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН ЭРҮҮЛ ҮЙЛ АЖИЛЛАГАА БА ЗАСАГЛАЛЫГ БЭХЖҮҮЛЭХ

ТӨСВИЙН САХИЛГА БАТЫГ БЭХЖҮҮЛЖ, САНХҮҮГИЙН СИСТЕМИЙГ ХӨГЖҮҮЛЭХ



Төсвийн орлогын бааз суурийг бэхжүүлж, төсвийн зардлын менежментийг урт хугацааны хөгжлийн бодлоготой уялдуулах, төсвийн сахилга бат, тогтвортой байдлыг нэмэгдүүлэх замаар санхүүжилтийн эх үүсвэрийг үр ашигтай хуваарилж, хөгжлийн бодлогыг үр дүнтэй хэрэгжүүлэхэд шаардлагатай төсвийн бааз суурийг өргөжүүлэхийг зорьж байна. Мөн санхүүгийн тэнцвэртэй зах зээлийг хөгжүүлэхийн тулд хөрөнгийн зах зээлийн хөгжүүлэхэд анхаарал хандуулна.

Жишээ: Их өгөгдөл ашигласан татварын удирдлагын чадавхыг бэхжүүлэх төсөл (ТХА) ЖАЙКА нь 1998 оноос хойш Монгол Улсын Татварын албатай хамтран Техникийн хамтын ажиллагаа, Хөгжлийн судалгаа, Сургалтын хамтын ажиллагааны хүрээнд тасралтгүй хамтран ажиллаж ирсэн бөгөөд 2023 оноос Их өгөгдөл ашиглан татварын удирдлагын чадавхыг бэхжүүлэх, ажлын урсгалыг сайжруулах замаар татварын удирдлагыг илүү үр ашигтай, үр дүнтэй хэрэгжүүлэхэд хувь нэмэр оруулж байна.



Жишээ: Төсвийн зохистой удирдлагад чиглэсэн төр, хувийн хэвшлийн түншлэлийн менежментийн чадавх бэхжүүлэх төсөл (ТХА) Төр, хувийн хэвшлийн түншлэлийн төсөл дэх төрийн болон хувийн хэвшлийн эрсдэлийг оновчтой тодорхойлж, болзошгүй өр төлбөрийн эрсдэлийг төсөв, санхүүгийн стратегид тусгах, улсын хөрөнгө оруулалтын менежментээр дамжуулан хувийн хэвшлийн оролцоог дэмжих орчныг бүрдүүлэх зорилготой.

ЗАСАГЛАЛЫГ БЭХЖҮҮЛЭХ

Нийгмийн дэд бүтцийн төсөл хөтөлбөрийг зөв, үр дүнтэй хэрэгжүүлэх чадвартай төрийн албаны хүний нөөцийг хөгжүүлэх, цахим шилжилтээр дамжуулан төрийн албаны чадавхийг сайжруулах зорилготой.

Жишээ: Кибер Аюулгүй Байдлын Хүний Нөөцийг Хөгжүүлэх Төсөл (ТХА) Монгол Улсад Аюулгүй цахим нийгмийг бий болгохын тулд Кибер аюулгүй байдлын талаарх боловсролыг дээшлүүлэх зорилгоор Төр, хувийн хэвшил, боловсролын салбарын гурвалсан холбоог бүрдүүлэхэд дэмжлэг үзүүлж, кибер аюулгүй байдлын боловсролын хөтөлбөрийг боловсруулж, хүний нөөцийг хөгжүүлэх үйл ажиллагааг хэрэгжүүлж байна.

Жишээ: JDS Хүний нөөц хөгжүүлэх тэтгэлэгт хөтөлбөр (буцалтгүй тусламж) 2001 оноос өнөөг хүртэл Япон Улсын их, дээд сургуулиудын магистр, докторын хөтөлбөрт Монгол Улсаас нийт 435 орчим хүнийг суралцуулсан. Эдгээр төгсөгчид нь өнөөдөр Монгол Улсын Их Хурлын гишүүдээс эхлээд төрийн байгууллагууд, Монгол банк, Санхүүгийн зохицуулах хороо зэрэг олон салбар, байгууллагад амжилттай ажиллаж байна.



2 ХҮРЭЭЛЭН БҮЙ ОРЧИНТОЙ ЗОХИЦСОН ЭДИЙН ЗАСГИЙН ТЭНЦВЭРТЭЙ ӨСӨЛТИЙГ ХАНГАХ

АЖ ҮЙЛДВЭРИЙН ТӨРӨЛЖҮҮЛЭЛТ БОЛОН ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ ҮЙЛДВЭРЛЭЛИЙГ ХӨГЖҮҮЛЭХ



Олон улсын ашигт малтмалын үнийн өөрчлөлтөд өртөмхий уул уурхайн ашигт малтмалд хэт хамааралтай байдлаас гарахын тулд хөдөө аж ахуй, мэдээллийн технологи, аялал жуулчлал зэрэг өсөлтийн нөөц боломжтой аж үйлдвэрийн салбарыг хөгжүүлэх, хөрөнгө оруулалтыг татах тал дээр анхаарч ажиллаж байна.

Жишээ: Жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх, Байгаль орчныг хамгаалах хоёр-үе шаттай иений хөнгөлөлттэй зээлийн төсөл Энэхүү төсөл нь аж үйлдвэрийг төрөлжүүлэх, ажлын байрыг нэмэгдүүлэх, байгаль орчныг хамгаалах чиглэлээр жижиг дунд бизнес эрхлэгчдэд үрт хугацаатай, хүү багатай санхүүгийн дэмжлэг үзүүлж ирсэн. Төслийн хүрээнд (1, 2-р шат) нийт 1,026 аж ахуйн нэгжид 382 тэрбум төгрөгийн дэмжлэг үзүүлж, 27,466 ажлын байрыг бий болгоод байна.

Жишээ: Зах зээлд суурилсан хөдөө аж ахуйг хөгжүүлэх төсөл

Төсөл хэрэгжих орон нутгийн онцлогт тохируулан зах зээлд суурилсан хөдөө аж ахуйг хөгжүүлэх замаар хүнсний ногоо тариалдаг өрхийн тариалан эрхлэгч болон аймаг сумдын хүнсний ногооны тариалалт хариуцсан хөдөө аж ахуйн газрын ажилтан нарыг чадавхжуулж, хүнсний ногооны дотоодын үйлдвэрлэлийг нэмэгдүүлэхэд чиглэсэн зах зээлд суурилсан хүнсний ногоо тариалалтын үр ашигтай тогтолцоог бий болгох. Улмаар хүнсний ногооны нийлүүлэлт болон хүнсний аюулгүй байдлыг сайжруулахад хувь нэмэр оруулах нь төслийн зорилго юм.



БАЙГАЛЬ ОРЧИНД ЭЭЛТЭЙ, ГАМШИГТ ТЭСВЭРТЭЙ ДЭД БҮТЦИЙГ БИЙ БОЛГОХ



Агаарын бохирдол зэрэг хотын хүрээлэн буй орчны асуудал руу чиглэсэн хамтын ажиллагаа болон өнөөг хүртэл дэмжлэг үзүүлж ирсэн хот төлөвлөлтийн салбарын хууль эрх зүй, тогтолцоог бүрдүүлэх хамтын ажиллагаанд тулгуурлан гэр хорооллын дахин төлөвлөлт, гамшгийн эрсдэлийг бууруулах үйл ажиллагааг эрчимжүүлэх замаар байгаль орчинд ээлтэй, аюулгүй хотыг бий болгоход хувь нэмэр оруулахыг зорьж байна. Мөн "Өндөр чанартай дэд бүтэц" гэсэн зарчмын үүднээс зам тээвэр, эрчим хүчний дэд бүтцийн бүтээн байгуулалт, зохистой менежмент, үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд чиглэсэн хамтын ажиллагааг хэрэгжүүлж, Монгол Улсын эдийн засгийн хөгжилд хувь нэмэр оруулах зорилго тавьж байна.

Жишээ төсөл: Улаанбаатар хотын Олон улсын нисэх онгоцны шинэ буудлын хамтын ажиллагаа (Иений хөнгөлөлттэй зээл, Техникийн хамтын ажиллагаа)

Агаарын тээврийн эрэлт нэмэгдэж буйтай холбогдуулан нийслэлийн нисэх онгоцны буудлын аюулгүй, найдвартай ажиллагааг сайжруулах зорилгоор шинэ нисэх онгоцны буудлыг барих төслийг иений хөнгөлөлттэй зээлийн санхүүжилтээр хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлсэн. Мөн шинэ нисэх онгоцны буудлыг саадгүй ашиглалтанд оруулах, нисэх буудлын зохистой менежмент, үйл ажиллагааг дэмжих зорилгоор техникийн хамтын ажиллагааны төслийг хэрэгжүүлсэн. Түүнчлэн өсөн нэмэгдэж буй эрэлтэд нийцүүлэхийн тулд одоогийн нисэх онгоцны буудлыг өргөтгөх асуудлыг хамтын ажиллагааны бэлтгэл судалгааны хүрээнд авч үзэж байна.



3 ХҮРТЭЭМЖТЭЙ НИЙГМИЙГ БИЙ БОЛГОХ

ЭРҮҮЛ МЭНДИЙН ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАР БА ХҮРТЭЭМЖИЙГ САЙЖРУУЛАХ



Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хүртээмжийн бүс нутгийн ялгааг арилгахын зэрэгцээ, дундаж давхаргын өсөлттэй уялдсан өвчлөлийн бүтцийн өөрчлөлтийг харгалзан эрүүл мэндийн тогтолцоог шинэчлэн хөгжүүлэх замаар Монгол Улсын эрүүл мэндийн үйлчилгээний түвшинг дээшлүүлэхэд хувь нэмэр оруулах хүний нөөцийг бэхжүүлж, улмаар эдийн засгийн өсөлтөд нийцсэн өндөр чанартай эмнэлгийн үйлчилгээ үзүүлэхийг зорьж байна.

Жишээ: Их сургуулийн эмнэлэг барих болон эрүүл мэндийн ажилтнуудын чадавхийг бэхжүүлэх (БТ/ТХА/Сайн дурын гишүүн) Туршлага бага хэдий ч ажлын байранд шууд томилогдон ажилладаг эмч нар олон бөгөөд эрүүл мэндийн салбарын хүний нөөцийн чанарыг сайжруулах шаардлага улам бүр нэмэгдэж байна. Иймд клиник дадлага хийх боломжтой Анагаах ухааны их сургуулийн харьяа эмнэлгийг буцалтгүй тусламжаар барьж, төгсөлтийн дараах сургалтыг сайжруулах Техникийн хамтын ажиллагааны төслийг хэрэгжүүлж байна. Мөн нийслэл, орон нутгийн эрүүл мэндийн байгууллагуудад сайн дурын гишүүдийг илгээж байна.

Жишээ: Монгол Улсын сургуулийн хоол үйлдвэрлэл үйлчилгээг дэмжих төсөл (ТХА)

· Сайн дурын гишүүн Ерөнхий боловсролын сургуулиудад аюулгүй, шим тэжээлийн тэнцвэртэй үдийн хоол өгөхөд дэмжлэг үзүүлэхийн зэрэгцээ хоол зүйчдийг бэлтгэдэг их сургууль болон Монгол Японы эмнэлэгт хоол зүйч сайн дурын гишүүдийг илгээх зэргээр амьдралын туршид үргэлжлэх шим тэжээлийг сайжруулах сүүрийг тавих, өвчнөөс урьдчилан сэргийлэхэд дэмжлэг үзүүлж байна.



НИЙГМИЙН СУУРЬ ҮЙЛЧИЛГЭЭГ БЭХЖҮҮЛЭХ




ЖАЙКА нь өнөөг хүртэл хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлт, нийгмийн оролцоог дэмжиж ажиллаж ирсэн бөгөөд халамжаас хөдөлмөр эрхлэлтэд чиглэсэн шилжилтийг хурдасгахаар зорилтот бүлгийн иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжин ажиллаж байна.

Жишээ: Монгол Улсын зорилтот бүлгийн иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих замаар бие даан амьдрахад дэмжлэг үзүүлэх тогтолцоог бэхжүүлэх төсөл (ТХА) Хөдөлмөр эрхлэлтийг дэмжин ажиллах үйлчилгээний зөвлөхийг бэлтгэх, аж ахуйн нэгжүүдэд ойлголт өгөх замаар зорилтот бүлгийн иргэдийн бие даан амьдрах, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тогтолцоог бий болгохоор зорьж байна.



МОНГОЛ УЛСАД ХЭРЭГЖҮҮЛСЭН ТӨСӨЛ, ХАМТЫН АЖИЛЛАГАА



1

Тусгай хэрэгцээт боловсрол шаардлагатай хүүхдэд үзүүлэх эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын үйлчилгээг сайжруулах төсөл



2

Ерөнхий боловсролын сургуулийн барилга барих төслийн 2-р шат Орхон аймаг



3

Монгол улсын анхан ба хоёр дахь шатлалын эмнэлгийн мэргэжилтний төгсөлтийн дараах сургалтыг сайжруулах төсөл




4

Зах зээлд суурилсан зөгийн аж ахуйг хөгжүүлэх төсөл



5

Ерөнхий боловсролын сургуулийн барилга барих төслийн 2-р шат Дархан-Уул аймаг



6

Дархан хотын усан хангамжийн байгууламжийг сайжруулах төсөл



7

Сонгиний шинэ сорт гарган брэнджүүлэх, сонгино тариалалтын нэмүү өртөгийн сүлжээг хөгжүүлэх төсөл



8

Суурь боловсролын чанарыг ахиулахад мэдээлэл харилцааны технологийг оновчтой ашиглах нь төсөл



9

Монгол Улсад гамшгийн эрсдлийг бууруулахад иргэдийн оролцоог хангах, гамшгаас урьдчилан сэргийлэх боловсрол олгох үйл ажиллагааг эрчимжүүлэх төсөл



10

Орон нутгийн иргэдэд түшиглэсэн заг хамгаалах, нөхөн сэргээх судалгаа



11

Хархорины музей барих төсөл



12

Цэций салхин цахилгаан станцын төсөл



13

Ариутгах татуургын цэвэрлэх хүчин чадлыг бэхжүүлэх төсөл



14

Гүн суулган тарих аргаар Дорнын говийн цөллөхөг бүсийн хуурай, хүйтэн газар нутгийг ургамалжуулах үйл ажиллагааг дэмжих төсөл



15

Улаанбаатар хотын Олон улсын нисэх онгоцны шинэ нисэх буудал барих төсөл



16

"Багануур", "Шивээ-Овоо" -гийн нүүрсний уурхайг хөгжүүлэх төсөл



17

Зах зээлд суурилсан хөвдөө аж ахуйг хөгжүүлэх төсөл



18

Төрийн болон Хувийн хэвшлийн малын эмч нарын практик чадавхийг бэхжүүлэх төсөл

Эрхэм зорилго

ЖАЙКА нь Хөгжлийн Хамтын Ажиллагааны үзэл баримтлалын хүрээнд хүний аюулгүй байдлыг ханган, чанартай хөгжлийг бий болгоно.

Алсын хараа

Даян дэлхийг итгэлээр холбоно. ЖАЙКА нь даян дэлхийн хүмүүс гэрэлт ирээдүйдээ итгэн, өргөн боломжийг эрэлхийлэх боломжтой, эрх чөлөөт, амар амгалан, баялаг дэлхийг цогцлоохыг эрмэлзэн түншлэгчтэйгээ эн зэрэгцэн алхаж, даян дэлхийг итгэлээр холбоно.

Үйл ажиллагааны зарчим

Үүрэг хариуцлага

Бахархал, хүсэл тэмүүлэлтэйгээр үүрэг хариуцлагаа биелүүлнэ.

Гэнба

Гэнба (ажлын талбар) руу ханцуй шамлан орж, хүмүүстэй хамтран ажиллана.

Стратеги

Стратегийн хувьд урт хугацаанд өргөн хүрээний алсын хараатай үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.

Хамтын бүтээл

Салбар бүрийн мэдлэг, нөөцийг нэг дор цуглуулна.

Инноваци

Урьд өмнө байгаагүй үр нөлөөг бий болгохын тулд шинэлэгээр сэтгэнэ.

ЖАЙКА-ИЙН МОНГОЛ ДАХЬ ТӨЛӨӨЛӨГЧИЙН ГАЗАР

Хаяг: Шангрила Центр 19 давхар, Олимпын гудамж, Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот

Утас: +976 7505-8778

И-мэйл: mg_oso_rep@jica.go.jp

Вэб: www.jica.go.jp/mongolia/index.html

FB: JICA Mongolia

